

UNITED MALL

ТАНИЛЦУУЛГА



UNITED MALL нь Улаанбаатар хотын хүчилтөрөгчийн хамгийн өндөр агууламжтай эрүүл цэвэр агаартай, шинэ суурьшлын бүс болох Хан-Уул дүүргийн 23-р хороо Арцатын аманд Нүхтийн зам дагуу байрлах орчин үеийн технологийн шийдэлтэй худалдаа үйлчилгээний төв юм.

Манай бүтээн байгуулалт нийтдээ 1,5 га талбайг хамрах бөгөөд 19,000мкв худалдаа, үйлчилгээ, оффис, олон үйлдэлт танхимтай кино театр болон 22 давхар шилэн фасад бүхий 80 айлын төлөвлөлттэй өндөр зэрэглэлийн орон сууцнаас бүрдэнэ.

UNITED MALL худалдаа, үйлчилгээний төв нь 18,000 айл өрх бүхий хүн амын төвлөрөл ихтэй бүсэд байрласнаараа бизнесийн урт хугацааны үнэ цэн, зогсолтгүй эргэлдэх идэвхтэй орон зайг бүлдүүлж байна.

B1 давхарт олон улсын сүлжээ дэлгүүр, 128 дулаан зогсоол

1-3 давхарт кино театр, кофе шоп, бэйкери, түргэн хоол, ресторан, хүүхдийн хувцас хэрэглэл, тоглоомын төв, үнэт эдлэл, нүдний шил, гоёл чимэглэл, цэцэг, бэлэг дурсгал, бичиг хэрэг, гэр ахуйн бараа

4-7 давхарт оффис, эмнэлэг, гоо сайхны үйлчилгээ

8 давхарт 800мкв 200-250 хүний багтаамжтай, орчин үеийн, өндөр зэрэглэлийн европ хоолны Магнет ресторан

Гадна болон дотор талбайн зохион байгуулалтад үйлчлүүлэгчдийн цаг, тав тухыг нэн тэргүүнд тооцож, 400 автомашины зогсоол бүхий шийдлийг бүрэн тусгасан.

Айл өрхийн өдөр тутмын хэрэгцээ, амралт чөлөөт цагийг бизнесийн боломжтой уялдуулсан нээлттэй, аюулгүй, ухаалаг төлөвлөлттэй орчин бүрдүүлсэн нь гэр бүлээрээ ая тухтай үйлчлүүлэх, ажил хэрэг, бизнесээ өргөжүүлэх, хамтын хөгжлийг илэрхийлнэ.

04.

UNITED MALL нь гэр бүлд тав тух, хүртээмж, бизнес эрхлэгчдэд бизнесийн өсөлт, тогтвортой хөгжил, урт хугацааны үнэ цэнийг санал болгож байна.

UNITED MALL нь үйлчлүүлэгч болон бизнес эрхлэгчдэд аюулгүй байдал, тав тухтай орчныг бүрдүүлэх үүднээс дараах шийдлүүдийг тусгаж өгсөн. Үүнд :

- ◆ Зөв урсгалтай орц гарцын зохион байгуулалт
- ◆ Бүх давхрууд 24 цагийн аюулгүй, камерын хяналтын смарт систем
- ◆ Галын дохиолол агааржуулалтын систем, болон хөргөлтийн нэгдсэн систем



FEATURE



ДАВУУ ТАЛ, ТОНОГЛОЛ

Төслийн дотоод тоноглолд Италийн TOTO брэндийн өндөр чанартай тоноглол, шийдлүүдийг ашигласан бөгөөд эдэлгээ, аюулгүй байдал, гоо зүйн хувьд найдвартай сонголт болсон.

Барилгын төвийн шугам сүлжээг зэвэрдэггүй ган хоолойгоор шийдсэн нь урт хугацааны ашиглалт, найдвартай ажиллагааг хангана.

Аюулгүй байдлын хувьд бүрэн автоматжуулсан галын дохиолол, унтраах системтэй бөгөөд осол, эрсдэлийг эрт илрүүлэх, шуурхай хариу үйлдэл үзүүлэх боломжийг бүрдүүлсэн.


Нэгдсэн агааржуулалтын системтэй тул дотоод орчны агаарын чанар, тав тухтай нөхцөлийг бий болгоно.

Хөргөлтийн шийдлийг TCL брэндийн цогц системээр гүйцэтгэж, эрчим хүчний хэмнэлттэй, үрашигтай ашиглалтыг бүрэн хангасан.

Барилгын хийц, гадна фасадын хувьд үзэгдэх орчин сайтай 3 давхар шилэн болон 100 жилийн насжилттай метал фасад ашиглаж, хана болон шалыг байгалийн гантиг чулуугаар шийдэж өгснөөр төслийн бат бөх байдал, орчин үеийн дүр төрхийг тодотгоно.

Цэлгэр том, харууц сайтай цонхны төлөвлөлт нь байгалийн гэрэл сайн нэвтрэх боломжийг бүрдүүлж, худалдаа үйлчилгээ эрхлэхэд таатай орчныг бий болгоно.

Зөв урсгалтай орц, гарцын зохион байгуулалтайгаас гадна бүх давхарт камерын хяналтын смарт систем суурилуулснаар хүний урсгал тоолох болон хянах боломжийг бүрдүүлж өгсөн.



УРИА ҮГ:

New City
NEW EXPERIENCE

АЛСЫН ХАРАА:

Шинэ хотын амьдралыг тодорхойлох жишиг худалдаа, үйлчилгээний төв болох

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Гэр бүл, амьдралын хэв маяг, бизнесийн хэрэгцээг нэг дор уялдуулсан цогц худалдаа үйлчилгээний орчныг бий болгон шинэ соёлыг түгээнэ

ҮНЭТ ЗҮЙЛС:

ИТГЭЛ
ТУРШЛАГА
СЭТГЭЛ ХАНАМЖ

СТРАТЕГИ:

Менежмент, түрээслэгч, хэрэглэгчийн нэгдсэн тогтолцоо

ФИЛОСОФИ:

Бид шинэ хотын амьдралыг барилгаар бус, туршлагаар бүтээнэ



БАГ ХАМТ ОЛОН:

Бид хариуцлага, харилцан итгэлцэлд суурилсан хамтын ажиллагааг эрхэмлэн, эрч хүч, мэргэжлийн ур чадвар, нээлттэй соёл, тасралтгүй сайжруулалтад тулгуурлан тогтвортой өсөлт, урт хугацааны үнэ цэнийг бүтээнэ.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА:

Бид үйл ажиллагаандаа нийгмийн хариуцлага, хүний хэрэгцээг дээдэлсэн хүртээмжтэй орчныг тэргүүн зорилго болгон хэрэгжүүлж байна. Тиймээс тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчид болон гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн ариун цэврийн өрөө, хүүхэд хуурайлах зориулалтын орчныг шийдэж, хүн бүрт тэгш, аюулгүй, ая тухтай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд байгалийн нөөцийг хэмнэх, байгаль орчинд ээлтэй шийдлүүдийг нэвтрүүлж, эрчим хүчний хэмнэлттэй LED гэрэлтүүлэг, орчин үеийн агаар сэлгэлтийн системийг төлөвлөн ашиглалтад оруулсан. Мөн орчны ногоон байгууламжийг цогцоор нь шийдэж, хотын өнгө үзэмж, экологийн тэнцвэрийг дэмжсэн, эрүүл, таатай нөхцлийг бүрдүүлсэн.



ХАРИЛЦАГЧ, ТҮРЭЭСЛЭГЧ:

Хөршийн бодлогыг нэгдүгээрт тавьж, салбар бүрийн онцлогийг шингээсэн зөв хэрэгцээт концепц бүхий, чанартай түрээслэгчидтэй урт хугацаанд үнэ цэнтэй хамтын ажиллагааг эрхэм болгож байна.

Харилцан итгэлцэлд суурилсан, найрсаг түншлэлийн хүрээнд смарт оффисын уян хатан шийдэл, тав тухтай худалдаа үйлчилгээний орчныг бүрдүүлж, бизнесийн өсөлт, амжилтыг хамтдаа бүтээх үнэ цэнийг бий болгоно.



ХЭРЭГЛЭГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ:

Таны цаг, тав тух, амьдралын хэв маягийг эрхэмлэсэн ухаалаг, орчин үеийн орон зайг бий болгож, чанартай үйлчилгээ, тав тухтай орчин, хоол, үзвэр, худалдан авалт, чөлөөт цагийг нэг дор төвлөрүүлсэн цогц шийдлийг бид танд санал болгож байна.

New city, new experience.

UNITED MALL





arrefour
market



UNITED CINEMA



КИНО ТЕАТР

Орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөгдсөн, олон үйлдэлт 4 танхим бүхий кино театр нь зөвхөн кино үзвэр төдийгүй бизнес, соёл, олон улсын арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн орчин юм. Дэвшилтэт дуу, дүрсний систем, уян хатан суудлын зохион

байгуулалт, тайз, дэлгэцийн олон хувилбарт шийдлүүдтэй учраас бизнес уулзалт, хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэг, нээлттэй лекц, брэндийн танилцуулга, бүтээгдэхүүний нээлт, олон улсын тэмцээн уралдаан, шууд дамжуулалт бүхий арга хэмжээг зохион байгуулах бүрэн боломжтой.

New City
NEW EXPERIENCE

1-3

ДАВХАР

Гэр бүлээрээ тухлан зочлох, орчин үеийн амьдралын хэв маягт нийцсэн цогц орон зайг бүрдүүлсэн.

Аюулгүй байдал, цэвэр тохилог орчин, чанартай үйлчилгээ, гэр бүлийн хэрэгцээт брэндүүд болон чанартай тасгуудыг нэг дор төвлөрүүлсэн нь энэхүү бүсийн онцлог юм.

Уг давхрууд нь ресторан, хоол үйлчилгээ, үзвэр үйлчилгээний цогц шийдлээс гадна 4 танхим бүхий орчин үеийн техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан олон үйлдэлт кино театрттай. Мөн хүүхэд багачуудад зориулсан аюулгүй, сонирхолтой тоглоомын бүсийг тусгайлан


төлөвлөсөн нь гэр бүлийн бүх гишүүдийн хэрэгцээг нэг дор хангах боломжийг бүрдүүлнэ.

Таны амьдралын шинэ хэв маяг, хэмнэлд нийцүүлсэн байдлаар ухаалгаар төлөвлөгдсөн кино театр, кофе шоп, бэйкери, түргэн хоол, ресторан, эрэгтэй эмэгтэй бэлэн хувцас, гутал цүнх, хүүхдийн хувцас хэрэглэл, тоглоомын төв, үнэт эдлэл, нүдний шил, гоёл чимэглэл, цэцэг, бэлэг дурсгал, ном бичиг хэрэг, гэр ахуйн бараа, технологи болон чөлөөт цагийн бүсүүд нь худалдан авалт, амралтыг нэг дороос бүрэн авах, цаг хугацааг хэмнэх цогц орчин болж байна.


1-р давхар



2-р давхар



3-р давхар





12.

4-9

ДАВХАР

UNITED MALL

Оффис, ресторан, эмнэлэг, гоо сайхны салони зориулалттай бөгөөд стратегийн байршилд орчин үеийн төлөвлөлт, уян хатан түрээсийн боломж урт хугацааны хамтын ажиллагаанд чиглэсэн бодлого баримтлан ажиллаж байна.



ДАВХРЫН ТӨЛӨВЛӨЛТ

9F | Оффис

8F | Магнет ресторан

7F | Оффис, Эмнэлэг үйлчилгээ

4F

3F | Хүүхдийн гутал хувцас, Хүүхдийн тоглоом, дагалдах хэрэгсэл, Кино театр, Kids zone, desert corner, Pop up

2F | Эрэгтэй эмэгтэй бэлэн хувцас, Хүүхдийн хувцас, хэрэглэл, Гутал цүнх, Ноос ноолуур, Технологи, Pop up store

1F | Гоо сайхан, Гоёл чимэглэл, Үнэт эдлэл, Mom's touch, Нүдний шил, Caffe bene, Tous Les Jours, Бичиг хэрэг, цэцэг, бэлэг дурсгал, Эмийн сан, Органик шоп, Бусад үйлчилгээ, Pop up store, Үнэт эдлэл

B1 | Супер маркет, зогсоол




INTERIOR



14.

UNITED MALL



ДАВХАР



UNITED MALL





☎ 7720 2929

🌐 www.unitedmall.mn

📍 Монгол улс, Улаанбаатар хот,
Хан-уул дүүрэг, 23-р хороо,
Нүхтийн зам, Арцатын ам
/17100/
UNITED MALL



📍 ГҮМҮДА ГАРДЕН

📍 ХҮННҮ АПАРТМЕНТ

📍 GREEN GARDEN



НҮХТИЙН ЗАМ
НҮХТИЙН ЗАМ